# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 23 (404)

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

- *Академич хэргэм хүртээх тухай*
- *Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай*
- *Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2005 он**

// ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2005 оны зургаадугаар сарын 21 №23 (404)

## Гарчиг

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 756. | Журам батлах тухай | Дугаар 127 | 494 |
| 757. | Академич хэргэм хүртээх тухай | Дугаар 128 | 494 |
| 758. | Дүрэмт хувцасны загварыг батлах тухай | Дугаар 130 | 495 |
| 759. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 131 | 504 |
| 760. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 132 | 504 |
| 761. | Чойжилжавын Цэрэннадмидад Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай | Дугаар 133 | 504 |
| 762. | Нацагийн Жанцанноровт Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 134 | 504 |
| 763. | Дашийн Пүрэвжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 135 | 505 |
| 764. | Даваахүүгийн Сэргэлэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 136 | 505 |
| 765. | Бямбаагийн Нямтайширт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай | Дугаар 137 | 505 |
| 766. | Банзрагчийн Батчулуунд Монгол Улсын гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 138 | 505 |
| 767. | Ринченгийн Барсболдод Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 139 | 506 |
| 768. | Сухрагчаагийн Нямзагдад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 140 | 506 |
| 769. | Базарын Хатанбаатарт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай | Дугаар 141 | 506 |
| 770. | Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 142 | 506 |
| 771. | Т. Гансүхийг "Шударга журам" медалиар шагнах тухай | Дугаар 143 | 510 |
| 772. | Морроу Жеймс Питерийг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 144 | 511 |
| 773. | Академич хэргэм хүртээх тухай | Дугаар 146 | 511 |
| 774. | Сандагдоржийн Жамъянсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 147 | 512 |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 6 дугаар сарын 03-ны өдөр | Дугаар 127 | Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дипломат дээд цол олгох ёслолын журмыг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 6 дугаар сарын 3 –ны өдрийн 127 дугаар зарлигийн хавсралт*

### ДИПЛОМАТ ДЭЭД ЦОЛ ОЛГОХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

**Нэг**. Ерөнхий заалт

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хүртээсэн "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин", "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд" дипломат дээд цолыг олгоход энэ журмыг баримтална.

2. Дипломат дээд цол олгох ёслолыг Төрийн ордны "Соёмбо" танхимд зохион байгуулна.

3. Дипломат дээд цолны үнэмлэх, батламж бичгийг Монгол Улсын Ерөнхийлөгч гардуулна.

4. Дипломат дээд цол олгох ёслолд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх, дипломат дээд цол хүртэгчийн удирдах эрх бүхий албан тушаалтан байлцана.

**Хоёр**. Ёслол үйлдэх журам

5. Дипломат дээд цол олгох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан уншина.

6. Зарлигийг уншсаны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч дипломат дээд цолны үнэмлэх, цол хүртээсэн батламжийг гардуулж, баяр хүргэнэ.

7. Дипломат дээд цол хүртэгч Монгол Улсын Ерөнхийлөгчид талархал илэрхийлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 6 дугаар сарын 07-ны өдөр | Дугаар 128 | Улаанбаатар хот

### Академич хэргэм хүртээх тухай

Дэлхийн болон өөрийн орны шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйлсэд эрдэмтдийн оруулж буй хувь нэмрийг төрөөс хүндэтгэх, Шинжлэх ухааны академийн гишүүний нэр алдрыг өргөмжлөх, эрдэм судлалын ажлыг урамшуулах зорилгоор Монгол Улсын Шинжлэх ухааны академийн гишүүдийн удаа дараа гаргаж буй санал, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийг тус тус үндэслэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1.Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Их чуулганаас академийн гишүүнээр сонгогдсон эрдэмтдэд ШУА-ын ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр "Академич" хэргэм хүртээж байсугай.

2.Академич хэргэм хүртсэн ШУА-ийн гишүүдэд энгэрийн тэмдэг, жуух гардуулж байсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 6 дугаар сарын 07-ны өдөр | Дугаар 130 | Улаанбаатар хот

**Дүрэмт хувцасны загварыг батлах тухай**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад тусгай албан тушаал эрхэлдэг алба хаагчдын дүрэмт хувцасны загварыг хавсралтын ёсоор батлагсугай.

2. Энэхүү зарлигийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 130 дугаар зарлигийн хавсралт*

### ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГАД ТУСГАЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ АЛБАН ХААГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ЗАГВАР

1. Өвлийн малгай /комиссар, дээд ахмад саарал өнгөтэй каракуль, бусад цолтонгууд саарал өнгөтэй цегейк малгай өмсөнө, загварын код 1-01, 02/



2. Комиссарын ёслолын саравчтай малгай /цайвар хөх өнгөтэй, улбар шар өнгийн хүрээ, хавчуургатай, загварын код 1-03/



3. Ёслолын саравчтай малгай / цайвар хөх өнгөтэй,улбар шар өнгийн хавчуургатай, загварын код 1-04/



4. Зуны дугуй малгай /хар өнгөтэй, загварын код 1-05/



5. Эрэгтэй савхин дээл /хар хөх өнгөтэй, загварын код 2-01/



6. Эмэгтэй савхин дээл /хар хөх өнгөтэй, загварын код 2-02/



7. Эрэгтэй цув /цайвар хөх өнгөтэй, загварын код 2-03/



8. Эмэгтэй цув /цайвар хөх өнгөтэй, загварын код 2-04/



9. Комиссарын ёслол, албаны китель /цайвар хөх өнгөтэй, ханцуй, зах улбар шар өнгийн хавчуургатай, загварын код 3-01/



10. Ёслол, албаны китель /эрэгтэй,цайвар хөх өнгөтэй, ханцуй, зах улбар шар өнгийн хавчууртай, загварын код 3-02/



11. Ёслол, албаны өмд /эрэгтэй, цайвар хөх өнгөтэй, хоёр хажуугийн тууш оёдол улбар шар өнгийн хавчууртай, загварын код 3-03/



12. Ёслол, албаны китель /эмэгтэй, ханцуй, зах улбар шар өнгийн хавчуургатай, цайвар өнгөтэй, загварын код 3-05/



13. Ёслол, албаны өмд /эмэгтэй,цайвар хөх өнгөтэй, хоёр хажуугийн тууш оёдол улбар шар өнгийн хавчуургатай, загварын код 3-06/



14. Ёслол албан юбка /цайвар хөх өнгөтэй, хоёр хажуугийн тууш оёдол улбар шар өнгийн хавчуургатай, загварын код 3-07/



15. Цамц /эрэгтэй, ёслолын цагаан, албаны цэнхэр өнгөтэй, загварын код 4-01, 02/



16. Цамц /эмэгтэй, ёслолын цагаан, албаны цэнхэр өнгөтэй, загварын код 4-03, 04/



17. Цол, ялгах тэмдэг /загварын код-5/

Комиссарын цолны тэмдэг 5-01



Ахмадын цолны тэмдэг 5-02




Дэслэгчийн цолны тэмдэг 5-03




Түрүүчийн цолны тэмдэг 5-04



Малгайн тэмдэг 5-05



Дүрэмт хувцасны товч 5-06



Байгууллагын билэг тэмдэг 5-07




Ханцуйн тэмдэг 5-08



18. Мөрдөс /Загварын код-6/

Тэргүүн комиссар: 6-01



комиссарын мөрдөс



Ахмадын мөрдөс: 6-02

/дээд ахмад/



/тэргүүн ахмад/



/шадар ахмад/




Дэслэгчийн мөрдөс: 6-03

/дээд дэслэгч/



/тэргүүн дэслэгч/



/шадар дэслэгч/




Түрүүчийн мөрдөс: 6-04

/дээд түрүүч/



/тэргүүн түрүүч/



/шадар түрүүч/



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 08-ны өдөр** | **Дугаар 131** | **Улаанбаатар хот**

### Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр ажил, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Очирбатын Чулуунцэцэгийг Архангай аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Батжаргалын Батзоригийг Ховд аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 08-ны өдөр** | **Дугаар 132** | **Улаанбаатар хот**

### Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Очирбатын Чулуунцэцэгийг Архангай аймгийн шүүхийн шүүгчийн, Батжаргалын Батзоригийг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн, Нарангэрэлийн Энхмааг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Банзрагчийн Дашдондовыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 133** | **Улаанбаатар хот**

### Чойжилжавын Цэрэннадмидад Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт эмч, багш, удирдах ажилтнаар он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж дотрын өвчин, цусны эмгэг судлалын тусламжийг хөгжүүлж, олон мянган эмч шавь сурган бэлтгэж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлст оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн багш, Улсын клиникийн төв эмнэлгийн дотрын ерөнхий зөвлөх эмч Чойжилжавын Цэрэннадмидад Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 134** | **Улаанбаатар хот**

### Нацагийн Жанцанноровт Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Соёл, урлагийн байгууллагад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж монголын төрийн соёлын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, тайз, дэлгэцийн болон үндэсний хөгжмийн томоохон олон бүтээл туурвиж урын санг баяжуулах, гадаад орнуудад сурталчлах, монголын орчин цагийн хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж хөгжмийн зохиолч, судлаач Нацагийн Жанцанноровт Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 135** **Улаанбаатар хот**

**Дашийн Пүрэвжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгон, үр ашгийг дээшлүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн "Талх чихэр" ХК-ийн техникийн асуудал хариуцсан дэд захирал Дашийн Пүрэвжат Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 136** **Улаанбаатар хот**

**Даваахүүгийн Сэргэлэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Үйлдвэрлэл, үйлчилгээний хувийн хэвшлийн салбар, нэгжүүдийг үүсгэн байгуулж, олон хүнийг ажлын байраар ханган, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Эрэл" ХХК-ийн ерөнхий захирал Даваахүүгийн Сэргэлэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 137** **Улаанбаатар хот**

**Бямбаагийн Нямтайширт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай**

Уул уурхайн салбарт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж алт, нүүрс олборлож, геологи хайгуулын судалгаа хийж, үйл ажиллагаагаа өргөтгөн, ажлын байр шинээр бий болгож, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Монголын алт" ХХК-ийн ерөнхийлөгч Бямбаагийн Нямтайширт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 138** **Улаанбаатар хот**

**Банзрагчийн Батчулуунд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж мэдрэлийн мэс заслын шинэлэг аргууд, мэдээллийн технологийн ололтуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлэн, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Банзрагчийн Батчулуунд хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 139 | Улаанбаатар хот

**Ринченгийн Барсболдод Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Шинжлэх ухааны байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Төв Азийн үлэг гүрвэлийн аймгийн бүтэц, бүрэлдэхүүн, ангилал зүй, түүхэн хөгжлийн талаар судалгаа явуулж, эрдэм судлалын олон бүтээл туурвиж, палеонтологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, эх орноо сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн Палеонтологийн төвийн захирал Ринченгийн Барсболдод Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 140 | Улаанбаатар хот

**Сүхрагчаагийн Нямзагдад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай**

Төрийн болон боловсролын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эрдэм судлалын бүтээлүүд туурвиж, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн захирал Сүхрагчаагийн Нямзагдад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 141 | Улаанбаатар хот

**Базарын Хатанбаатарт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай**

Шатрын спортоор дэлхий, тив, олон улсын, улсын аварга шалгаруулах тэмцээнд удаа дараа амжилттай оролцож, Дэлхийн шатрын их мастер цол болон шатрын олимпийн хүрэл медаль хүртэж шатрын спортыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Базарын Хатанбаатарт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 142 | Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, нисэх хүчин, татвар, даатгал, банк, уул уурхай, ашигт малтмал, тээвэр, дулаан, эрчим хүч, хил хамгаалалт, хэвлэл мэдээлэл, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил идэвхи санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**СҮХБААТАРЫН ОДОНГООР:**

Балдангийн Янжмаа- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт

## ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Төгөөгийн Батбаяр- "Капитал" банкны зөвлөх

2. Замбалгаравын Жадамба- Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн орлогч дарга

3. Очирын Лхагваранцэн- Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ахлах зохион байгуулагч

4. Чимэдхүүгийн Намнан- Завхан аймгийн Яруу сумын Хэц-Улаан багийн малчин

5. Жанлавын Наранцацралт- Монгол Улсын Их Хурлын гишүүн, Дэд бүтцийн байнгын хорооны дарга

6. Цэрэнбалжидын Самбаллхүндэв- Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга

7. Даваажавын Сосорбарам- Сангийн яамны харьяа Банкны өр барагдуулах газрын дарга

8. Намжилдоогийн Чадраабал-Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн

9. Миеэгомбын Энхболд- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Цэнджавын Цэрэндорж-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн захирагч, хурандаа

## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Горчинсүрэнгийн Адъяа- Монгол Улсын Их Хурлын гишүүн

2. Гомбосүрэнгийн Амарбат- Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн гадаад худалдааны хэлтсийн дарга

3. Гарамын Аюурбуниа- Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын орон нутгийн өмчийн төлөөлөгч

4. Дамдины Баасанжаргал- "Монголын мэдээ" сонины албаны дарга

5. Авирмэдийн Баатархүү- Завхан аймгийн Дөрвөлжин сумын 8 жилийн сургуулийн хөдөлмөрийн багш

6. Доржсүрэнгийн Бадарч - Үйлдвэр худалдааны яамны Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын дарга

7. Лувсандамбын Батмөнх- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Техник үйлчилгээний төвийн дарга

8. Лхасүрэнгийн Батнацаг- Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг дарга

9. Пүрэвийн Батсайхан- Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Шунхлай групп" ХХК-ийн ерөнхийлөгч бөгөөд "АПУ" ХК-ийн гүйцэтгэх захирал

10. Цэрэнжидийн Батсуурь- ТЗҮААЭГ-ын харъяа авто баазын жолооч

11. Омбогийн Батсүх- ЭМШУИС-ийн мэс заслын 2 дугаар тэнхмийн ахлах багш

12. Даржаагийн Баттөмөр- ТЗҮААЭГ-ын харъяа авто баазын жолооч

13. Чимэддоржийн Баттөмөр-Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Бүтээгдэхүүн хуваах гэрээ, шинэ төслийн газрын дарга

14. Наваандаржаагийн Батхүрэл- ЭМШУИС-ийн хүн хүчний хэлтсийн дарга

15. Санжийн Батхүү- "МИАТ" ХК-ийн санхүүгийн ерөнхий менежер

16. Өвгөний Батцоож- Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн дэд захирал

17. Түвшинтөгсийн Батцэцэг- ГХЯ-ны хөрөнгө оруулалтын газрын 3 дугаар нарийн бичгийн дарга

18. Дамдинсүрэнгийн Галбаатар-Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн хэлтсийн дарга

19. Баасанжавын Ганболд- Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга

20. Цэрэндоржийн Даржаа-Ховд аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн дэд захирал

21. Бүрнээгийн Дашдондог-Завхан аймгийн авто тээврийн "Завхан тээх" ХК-ийн жолооч

22. Балдангийн Дашзэвэг-Завхан аймгийн авто тээврийн "Завхан тээх" ХК-ийн жолооч

23. Дийзэнгийн Дүгэрсүрэн- Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга

24. Найдангийн Жаргал- ТЗҮААЭГ-ын харъяа авто баазын жолооч

25. Шагжийн Жаргалсайхан- Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга

26. Наваанын Лхагва- Нийслэлийн геологи, уул уурхайн "Хүдэр-Эрдэнэ" ХХК-ийн дэд захирал

27. Батаагийн Мөнхжаргал- Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёлын газрын дарга

28. Жамцын Наранцэцэг- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Мон-Алтай" ХХК-ийн захирал

29. Рагчаагийн Наранцэцэг- Нийслэлийн Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга

30. Балдандоржийн Нацагням- Төв аймгийн Дулааны эрчим хүчний газрын захирал

31. Маахүүгийн Нямхүү- Нийслэлийн Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч

32. Доржийн Одбаяр- Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга

33. Сандагийн Оросоо- ТЗҮААЭГ-ын харьяа авто баазын жолооч

34. Өргөнбаагийн Осоржамаа- ТЗҮААЭГ-ын харъяа хэвлэх үйлдвэрийн нярав

35. ОчиржанцангийнОюунцэцэг- Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын "Хүдэр -Дулаан" орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын дарга

36. Пүрэвийн Оюунчулуун- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Янгир хайрхан" ХХК-ийн захирал

37. Бадамгаравын Пүрэвсүрэн- Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн байцаагч инженер

38. Нэгийн Сүхбат- "Зоос" банкны 101 дүгээр салбарын захирал

39. Содовын Тамжид- Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн 40 дүгээр сургуулийн түүх газарзүйн багш

40. Базаргордоогийн Тогоо- Нийслэлийн "Очирбат сан" ТББ-ын жолооч

41. Цэвгээгийн Тогтохбаяр- Нийслэлийн "Ард даатгал" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

42. Гүнжидийн Төмөрбаатар- УБТЗ-ын Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

43. Баатарын Туул- ТЗҮААЭГ-ын харъяа "Элит" төвийн дарга

44. Балдангийн Түвээгомбо- Завхан аймгийн Түдэвтэй сумын Аргалант багийн Засаг дарга

45. Сүхбаатарын Уртнасан- Төв аймгийн Баян сумын 1 дүгээр багийн малчин

46. Чойжилсүрэнгийн Цагаан- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Баян-Ойт" цогцолбор сургуулийн эрхлэгч

47. Сэрээнэндоржийн Циенхүү - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Ургамал-3М" ХХК -ийн захирал

48. Дамдины Цогтбаатар- Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх

49. Жамъянгийн Цэндсүрэн- Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Мон-Өл-Экс" ХХК-ийн захирал

50. Янживын Цэрэндулам- Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

51. Рэнцэнпүрэвийн Цэрэндолгор- Сангийн яамны ахлах мэргэжилтэн

52. Цагааны Чинбат- Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн хуулийн зөвлөх

53. Лутбаярын Чулуунбаатар- Нийслэлийн үйлдвэрлэл ,үйлчилгээний "Рич Могол" ХХК-ийн эдийн засагч

54. Нанзадын Чулуунбаатар-"Эх –Орон" намын Ерөнхий нарийн бичгийн дарга

55. Цэрэндоржийн Чулуунбат- "Харанга" рок хамтлагийн хөгжимчин, хөгжмийн зохиолч, дуучин

56. БатмөнхийнШаравдорж-Завхан аймгийн Яруу сумын холбооны салбарын эрхлэгч

57. Жугнээгийн Шишмишиг- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын ахлах мэргэжилтэн

58. Загдаагийн Энхбаяр- "МИАТ" ХК-ийн нислэгийн үйл ажиллагааны ерөнхий менежер, В-737 онгоцны дарга

59. Жалбуугийн Энэбиш- Зам тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн захиргаа удирдлагын газрын мэргэжилтэн

60. Чойжилсүрэнгийн Эрдэнэбат- Төв аймгийн Баянцогт сум дахь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн "Могол ноос" ХХК-ийн ерөнхий захирал

61. Ишхандын Юмчиндулам- Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:**

1. Лхамсүрэнгийн Ганбат- Төрийн тусгай хамгаалалтын газрын захиалга хүргэгч, дэслэгч

2. Пүрэвийн Ганбат- ХХЕГ-ын Хилийн тагнуулын албаны тасгийн дарга, дэд хурандаа

3. Хуяг-Очирын Ганбат- Төрийн тусгай хамгаалалтын газрын хангалт үйлчилгээний хэлтсийн дарга, хурандаа

4. Дагвадоржийн Дарьсүрэн- ЗЦГ-ын ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа

5. Бат-Өлзийн Жамбаа- Хилийн цэргийн 0132 дугаар ангийн захиргаа хүний нөөцийн тасгийн дарга, дэд хурандаа

6. Лхагвадоржийн Жаргалсайхан- ЗЦГ-ын хамгаалалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

7. Мөнхийн Лхагвасүрэн- Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн хилийн заставын дарга, дэд хурандаа

8. Эрдэнэ-Очирын Нарантуяа-Хилийн цэргийн 0253 дугаар ангийн санхүүгийн албаны дарга, дэд хурандаа

9. Мунаагийн Насан-Урт- ХХЕГ-ын Ар тал инженер техникийн газрын офицер, дэд хурандаа

10. Дамдинжавын Сугар- Төрийн тусгай хамгаалалтын газрын аюулгүй байдлын албаны дарга, хурандаа

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Лодойн Алтангэрэл- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын ахлах мэргэжилтэн

2. Сэрээнэнгийн Алтанцэцэг- Нийслэлийн Хүүхэд залуучуудын газрын дарга

3. Бадарчийн Амаржаргал- Зэвсэгт хүчний төв архивын мэргэжилтэн, фондын эрхлэгч

4. Хуспаханы Асхар- Баян-Өлгий аймгийн Буянт сумын 10 жилийн сургуулийн физикийн багш

5. Жамбын Баатаржав- Ховд аймгийн Жаргалант сумын 10 жилийн 3 дугаар сургуулийн математикийн багш

6. Базарын Балган- ХЗДХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

7. Гүрийн Батболд- Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ЗДТГ-ын хяналтын улсын байцаагч

8. Дарамрагчаагийн Батсүх- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын ахлах мэргэжилтэн

9. Баттулгын Баясгалан- Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч

10. Нацагийн Бүргэд- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын төлөөлөгч

11. Балдангийн Бэгзсүрэн- Завхан аймгийн авто тээврийн "Завхан тээх" ХК-ийн жолооч

12. Бямбажавын Ганбат- Сангийн яамны Төрийн сангийн удирдлагын газрын захиргаа хуулийн хэлтсийн дарга

13. Доржийн Готов- МАХН-ын Төв аймаг дахь хорооны улс төрийн ажилтан

14. Цэрэн-Очирын Дамдинсүрэн- Завхан аймгийн Яруу сумын Чандмана багийн Засаг дарга

15. Агваaны Дорж- Баянхонгор аймгийн авто зам, барилга засвар арчлалтын "Өргөн жим" ХК-ийн ерөнхий инженер

16. Жанчивсүрэнгийн Дорж- ТЗҮААЭГ-ын харъяа авто баазын жолооч

17. Сонинтөрийн Жимсээ- Ховд аймгийн Мөнххайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга

18. Цэдэндоржийн Ичинхорлоо-Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэгийн багш

19. Сэрээтэрийн Итгэлт- ТЗҮААЭГ-ын харъяа хэвлэх үйлдвэрийн техник редактор

20. Пүрэвсүрэнгийн Лхагвасүрэн- Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн мэргэжилтэн

21. Сайнбаярын Мөнгөнцэцэг- Сангийн яамны ахлах мэргэжилтэн

22. Галбадрахын Наранцэцэг- ХХЕГ-ын ангийн ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын хэлтсийн ахлах офицер, дэд хурандаа

23. Найдангийн Нямдорж- Завхан аймгийн Тээвэр зохицуулалтын албаны улсын байцаагч

24. Сосорбурамын Нямдорж- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга

25. Лхамсүрэнгийн Октябрь- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Дорнод аймаг дахь төлөөлөгч

26. Ядамсүрэнгийн Оюунбилэг-Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн ерөнхий сувилагч

27. Балдансамбуугийн Сарантуяа-Дархан-Уул аймгийн Шуудан холбооны газрын дарга

28. Пэлжээгийн Тамир- Улсын мэргэжлийн хяналтын газрын тээврийн хяналтын улсын ахлах байцаагч

29. Сампилын Таня- Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн математикийн багш

30. Консулханы Тойшубай- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга

31. Лхагвын Төмөрсүх- Баянхонгор аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" ХХК-ийн дизелийн засварчин

32. Сономын Тумэнжаргал- Ховд аймгийн Жаргалант сумын "Цаст-Алтай" цогцолбор сургуулийн газарзүйн багш

33. Гомбожавын Хандаа- Хилийн цэргийн 0288 дугаар ангийн оёдлын үйлдвэрийн эсгүүрчин

34. Задийн Цогбадрах -Дархан-Уул аймаг дахь барилгын "Дархан хөлөг" ХХК-ийн бригадын дарга

35. Балдандоржийн Шатар- Дундговь аймгийн Аудитын газрын ахлах аудиторч

36. Лхагвын Энхбаяр- Улсын мэргэжлийн хяналтын газрын усан зам тээврийн хяналтын улсын ахлах байцаагч

37. Сэрээнаагийн Энхбямба- Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч

38. Осорхүүгийн Энхтайван-Төв аймгийн Дулааны эрчим хүчний газрын механик

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Пүрэвийн Алтангэрэл- Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч

2. Нэхийтийн Алтанцэцэг- ХХЕГ-ын нян судлалын лабораторийн эрхлэгч, ахмад

3. Лхагвын Батзориг- Хилийн цэргийн 0130 дугаар ангийн инженер, зэвсэг химийн дарга, хошууч

4. Дэмбэрэлийн Болдбаатар- ХХЕГ-ын сургалт цэргийн албаны ахлах офицер, хурандаа

5. Чүлтэмийн Ганбаатар- Хилийн цэргийн 0132 дугаар ангийн хилийн тагнуулын ажилтан, дэд хурандаа

6. Баатархүүгийн Дашдорж- ЗЦГ-ын зохицуулагч цагдаа, цагдаагийн ахлагч

7. Амаржаргалын Диваачомбо- ХХЕГ-ын сургалтын албаны дарга, хурандаа

8. Нанзадын Тодгэрэл- Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын хөгжимчин, ахлах ахлагч

9. Чүлтэмсүрэнгийн Хишигдаваа- ХХЕГ-ын Хил хамгаалалтын газрын зураач, операторч, ахлах ахлагч

10. Цэрэндуламын Цагаандорж- Хилийн цэргийн 0119 дүгээр ангийн ерөнхий нягтлан бодогч

11. Сүрэнхоролын Цэдэндамба- Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын албаны дарга, дэд хурандаа

12. Жамъяны Чулуун - ХХЕГ-ын хүн эмнэлгийн албаны офицер, дэд хурандаа

13. Дарамбазарын Эрдэнэбилэг- ХХЕГ-ын барилга орон сууцны албаны инженер, дэд хурандаа

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 143** **Улаанбаатар хот**

**Т. Гансүхийг "Шударга журам" медалиар шагнах тухай**

Иргэний үүргээ нэр төртэй биелүүлэн, хүнд өвчтөнд олон удаа цусаа өгч, иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Увс аймгийн Улаангом сумын иргэн, хүндэт донор Тэгшийн Гансүхийг "Шударга журам" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 144** **Улаанбаатар хот**

**Морроу Жеймс Питерийг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монголын хөдөө аж ахуйн банкны бүтэц, зохион байгуулалт, удирдлагыг сайжруулан бэхжүүлж, манай улсын банк санхүүгийн салбарын хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж АНУ-ын иргэн, Хөдөө аж ахуйн банкны гүйцэтгэх захирал Морроу Жеймс Питерийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 10-ны өдөр** **Дугаар 146** **Улаанбаатар хот**

**Академич хэргэм хүртээх тухай**

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Шинжлэх ухааны академийн гишүүн доор нэр дурдсан эрдэмтдэд Академич хэргэм хүртээсүгэй.

| | *Академийн гишүүд* | *Академийн гишүүнээр сонгогдсон он* |
|---|---|---|
| 1. | Бадамын Лхамсүрэн | 1961 |
| 2. | Бутачийн Лувсанданзан | 1961 |
| 3. | Чимидийн Сэрээтэр | 1961 |
| 4. | Пүрэвийн Хорлоо | 1964 |
| 5. | Хишигийн Цэрэв | 1964 |
| 6. | Шагдарын Бира | 1973 |
| 7. | Пунцагдашийн Лувсандорж | 1975 |
| 8. | Баатарын Чадраа | 1975 |
| 9. | Чойдогийн Цэрэн | 1981 |
| 10. | Аюурын Дулмаа | 1982 |
| 11. | Төмөрийн Намжим | 1982 |
| 12. | Содномжамцын Норовсамбуу | 1982 |
| 13. | Цэндийн Хайдав | 1982 |
| 14. | Осорын Шагдарсүрэн | 1982 |
| 15. | Мятавын Төмөржав | 1987 |
| 16. | Дэмбэрэлийн Дашзэвэг | 1990 |
| 17. | Дамдинрагчаагийн Цэрэндорж | 1990 |
| 18. | Чилхаажавын Авдай | 1991 |
| 19. | Думаажавын Баатар | 1991 |
| 20. | Цээпилдоржийн Баатар | 1991 |
| 21. | Ринчений Барсболд | 1991 |
| 22. | Сэрээтэрийн Батмөнх | 1991 |
| 23. | Хавтгайн Намсрай | 1991 |
| 24. | Пагважавын Нямдаваа | 1991 |
| 25. | Онongийн Төмөртогоо | 1991 |
| 26. | Гэндэнгийн Чадраабал | 1991 |
| 27. | Чулууны Далай | 1994 |
| 28. | Эрээдэрийн Лувсандагва | 1994 |
| 29. | Раднаасүмбэрэлийн Гончигдорж | 1998 |
| 30. | Батын Гоош | 1998 |
| 31. | Дэчингунгаагийн Доржготов | 1998 |
| 32. | Надмидын Өлзийхутаг | 1998 |
| 33. | Домийн Төмөртогоо | 1998 |

| | | |
|---|---|---|
| 34. | Далантайн Цэрэнсодном | 1998 |
| 35. | Батболдын Энхтүвшин | 1998 |
| 36. | Жанцандоржийн Амгалан | 2000 |
| 37. | Начингийн Баасанжав | 2000 |
| 38. | Цэсрэнжавын Жанчив | 2000 |
| 39. | Содовсүрэнгийн Нарангэрэл | 2000 |
| 40. | Жүгнээгийн Амарсанаа | 2002 |
| 41. | Аюурзаны Болд | 2002 |
| 42. | Бадарчийн Бямбаа | 2002 |
| 43. | Түвдэндоржийн Галбаатар | 2002 |
| 44. | Түвдийн Дорж | 2002 |
| 45. | Лувсаннямын Лхагва | 2002 |
| 46. | Дүгэрийн Рэгдэл | 2002 |
| 47. | Хорлоогийн Сампилдэндэв | 2002 |
| 48. | Долгорсүрэнгийн Хайсамбуу | 2002 |
| 49. | Жигжидийн Болдбаатар | 2004 |
| 50. | Дэнсмаагийн Дүнгэрдорж | 2004 |
| 51. | Абишийн Мекей | 2004 |
| 52. | Бат-Өлзийн Цэрэндаш | 2004 |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 6 дугаар сарын 14-ний өдөр** **Дугаар 147** **Улаанбаатар хот**

### Сандагдоржийн Жамъянсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж шинэ техник, технологи нэвтрүүлэн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, чанар, үр ашгийг дээшлүүлэх болон нефтийн бүтээгдэхүүнээр улс эх орны хэрэгцээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Алтжин" группийн ерөнхийлөгч, САПУ үйлдвэрийн ерөнхий захирал Сандагдоржийн Жамъянсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**"Төрийн Мэдээлэл"** эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12,
Төрийн ордон
☎ 265958 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 267437
Хэвлэлийн хуудас 2.5